



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/703

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.4, 63.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, мөн зүйлийн 14.4 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.6 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/50 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хавсралтаар баталж, уг төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Чингэлтэй дүүргийн Засаг дарга (Н.Мандуул)-т шилжүүлэн, худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, үр дүнг танилцуулж ажиллахыг даалгасугай.


2.Захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай 6,933,100,000.0 (зургаан тэрбум есөн зуун гучин гурван сая нэг зуун мянга) төгрөгийн 3,466,700,000.0 (гурван тэрбум дөрвөн зуун жаран зургаан сая долоон зуун мянга) төгрөгийг “Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалт”-ын “191”-т заасан “Нийтийн эзэмшлийн явган хүний зам, талбайн тохижилтын ажил (Улаанбаатар хот)” ажлын хөрөнгөөс, 3,466,400,000.0 (гурван тэрбум дөрвөн зуун жаран зургаан сая дөрвөн зуун мянга) төгрөгийг “Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалт”-ын “43”-т заасан “Нийтийн эзэмшлийн явган хүний зам, талбайн тохижилтын ажил (Улаанбаатар хот)” ажлын хөрөнгөөс гүйцэтгэлээр нь холбогдох хууль, журмын дагуу хянан баталгаажуулж, санхүүжилтийн эрх нээхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Гантулга)-т, нээсэн эрхийг үндэслэн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Л.Эрдэнэбадрах)-т, захиалагчийн хяналт тавьж ажиллахыг “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ (Б.Мөнхбат)-т, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтад нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т тус тус даалгасугай.

1725023299

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалайд даалгасугай.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/1203 дугаар захирамжийн хавсралтаар баталсан жагсаалтын “5, 6” дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/21 дүгээр захирамжийн хавсралтаар баталсан жагсаалтын “6, 7” дахь заалтыг тус, тус хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

Нийслэлийн Засаг даргын 2025 оны
05 дугаар сарын 16-ны өдрийн
А/703 дугаар захирамжийн
хавсралт

НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	(сая төгрөг) 2025 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
1	Нийтийн эзэмшлийн явган хүний зам, талбайн тохижилтын ажил, Бага тойруугийн гудамж-Хойд хэсэг	2024	2025	3,931.4	3,931.4
2	Нийтийн эзэмшлийн явган хүний зам, талбайн тохижилтын ажил, Бага тойруугийн гудамж-Урд хэсэг	2024	2025	3,001.7	3,001.7
ДҮН				6,933.1	6,933.1

[illegible][illegible][illegible]